



## АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

Архангай аймаг 2024 он



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх  
аудитор **Т.Байгалмаа**

Утас: 77333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер **Д.Нэргүйбаатар**

Утас: 77332860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор **Г.Цог-Эрдэнэ**

Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn

Аудитор **Н.Энхчимэг**

Утас: 89891150 Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Аудитор **Л.Соёлмөнх**

Утас: 99051561 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах  
хаягаар авна уу.



<b>Тайлан бэлтгэсэн:</b> Архангай аймаг дахь Төрийн аудитын газар	<ul style="list-style-type: none"><li>➤ Товчилсон үгийн тайлбар ..... 3</li><li>➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй ..... 4</li><li>➤ Үндсэн мэдээлэл ..... 5</li><li>➤ Аудитын тайлан ..... 6-13</li></ul>
<b>Тэргүүлэх аудитор</b> Т.Байгалмаа	<b>БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС АРХАНГАЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ 19 СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО, 105 ХЭСГИЙН ХОРООНД ХУВААРИЛАН ЗАРЦУУЛСАН БАЙНА</b>  1.1.1 УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОХ ХӨРӨНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ БОДИТОЙ ТООЦСОН ЭСЭХ АСУУДЛЫГ СЕХ-НИЙ ХЭМЖЭЭНД АВЧ ҮЗЭХЭЭР БАЙНА.  1.1.2 СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН ХЭСГИЙН ХОРООДОД ТӨСВИЙГ ХУВААРИЛАХДАА СЕХ-НООС ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН УДИРДАМЖИЙГ МӨРДСӨН АЖИЛЛАСАН БАЙНА.  1.1.3 СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС НЬ ЗАРДЛЫГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛСАН БАЙНА.  <b>БҮЛЭГ 2. ЗАРИМ СОНГУУЛИЙН ХОРООД НЬ ТӨСВИЙГ ЗАРЦУУЛАХДАА ХОЛБОГДОХ ЖУРМЫН ШААРДЛАГЫГ МӨРДӨӨГҮЙ БАЙНА</b>  2.2.1. 2,957.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН БАЙНА.  2.2.2. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГ 13 СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.  2.2.3. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.  Дүгнэлт..... 12 Зөвлөмж ..... 13 Холбогдох байгууллагын санал ..... 14 Тайлан баталгаажуулсан тушаал..... 15-16 Хавсралт:Судалгаанууд ..... 17-21
<b>Аудитын менежер</b> Д.Нэргүйбаатар	
<b>Ахлах аудитор</b> Г.Цог-Эрдэнэ	
<b>Аудитор</b> Н.Энхчимэг, Л.Соёлмөнх	
2024 оны 08 дугаар сар Уг тайланг <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> сайтаас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу	
Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	



### Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт
АСХ	Аймгийн Сонгуулийн хороо
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗГ	Засгийн газар
ШТА	Шууд тайлагнах аудит
МТБ	Мэдээлэл технологийн баг
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
СНЖ	Сонгогчийн нэрийн жагсаалт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

### Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар аймгийн Сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв, гүйцэтгэл	5
Хүснэгт 2	СЕХ-оос хуваарилсан зардлын төсөв	6
Хүснэгт 3	УИХ-ын 2020, 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс баталсан төсөв, гүйцэтгэл	7
Хүснэгт 4	УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон төсвийг аймгийн сонгуулийн хороо болон 19 сумын сонгуулийн хороодод хуваарилсан байдал	8
Хүснэгт 5	Батлагдсан төсвийг зардлын ангиллаар харуулбал:	8
Хүснэгт 6	УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар аймгийн Сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв, гүйцэтгэл	10
Хүснэгт 7	Зардлын ангиллаар харуулбал	15
Хүснэгт 8	Сумын сонгуулийн хорооны зардлын тайлан, Аудитаар байвал зохих зардлын тайлангийн залруулга хийсэн дүнг харуулбал	15



**Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл**

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаал, Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт	Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг ҮАГ болон бусад холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>• УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;</li><li>• УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх асуудлыг тус тус хамруулав</li></ul>
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн сонгуулийн хороо, 19 сумдын сонгуулийн хороо, 105 хэсгийн хороо, аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсийг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт- Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>✓ Төрийн аудитын тухай хууль</li><li>✓ Төсвийн тухай хууль;</li><li>✓ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;</li><li>✓ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль</li><li>✓ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль</li><li>✓ Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль</li><li>✓ Дээрх хуулиудтай нийцүүлсэн гаргасан тогтоол, журам</li><li>✓ Батлагдсан төсөв, төсвийн хуваарь</li></ul>
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Л.Соёлмөнх нар хамтран гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.07.05-ны өдөр эхлүүлж, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр ҮАГ болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.



## Үндсэн мэдээлэл

Архангай аймгийн хэмжээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг аймгийн сонгуулийн хорооны 11 албан хаагч, 19 сумын сонгуулийн хорооны 133 ажилтан, 105 хэсгийн хорооны 708, мэдээлэл технологийн 131 ажилтан, улсын бүртгэлийн 106 итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 160 албан хаагчид ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны тамгын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/45 дугаар тушаалаар Архангай аймгийн сонгуулийн хороонд 1,089.1 сая төгрөгийн төсвийг хуваарилж, гүйцэтгэлээр 98.5 хувь буюу 1,073.2 сая төгрөгийг зарцуулж, үлдсэн 15.8 сая төгрөгийг СЕХ-ний дансанд буцаан төвлөрүүлжээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулах зардлын төсвийг 98.9 сая төгрөгөөр, 2024 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардлын төсвийг 4.5 сая төгрөгөөр нийт 103.5 сая төгрөгийг баталсан байна. Гүйцэтгэлээр 97.5 хувь буюу 100.9 сая төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 2.6 сая төгрөгийг УБЕГ-т буцаан төвлөрүүлжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсвөөс Архангай аймгийн Цагдаагийн газарт 39.8 сая төгрөгийг хуваарилсныг 100 хувь зарцуулжээ.

Хүснэгт №1. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар аймгийн Сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв, гүйцэтгэл

Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн
				хувь
Аймгийн сонгуулийн хороо	1,089,123.0	1,073,276.5	15,846.5	98.5
Аймгийн Цагдаагийн газар	39,822.0	39,822.0	-	100.0
Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	103,502.3	100,882.5	2,619.8	97.5

Архангай аймгийн хэмжээнд УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар 59471 иргэн санал өгөхөөс 66.9 хувь буюу 39804 иргэн сонгуульд оролцсон нь өмнөх УИХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн ирцээс 7.3 пунктээр буурсан байна.



**БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС АРХАНГАЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНД ХУВААРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ 19 СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО, 105 ХЭСГИЙН ХОРООНД ХУВААРИЛЖ ЗАРЦУУЛСАН БАЙНА**

**1.1.1. УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОХ ХӨРӨНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ БОДИТОЙ ТООЦСОН ЭСЭХ**

Энэ дэд асуудал нь Сонгуулийн Ерөнхий хорооны хүрээнд хамаарагдах асуудал байгаа тул аймгийн сонгуулийн хороонд шалгагдаагүй болно.

**1.1.2. СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН ХЭСГИЙН ХОРООДОД СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДЛЫГ ХУВААРИЛАХДАА СЕХ-НООС ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН УДИРДАМЖИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛАСАН БАЙНА.**

СЕХ-оос Архангай аймгийн сонгуулийн хороонд 5 удаагийн хуваарийн дагуу нийт 1,089,123.0 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна.

Хүснэгт № 2. СЕХ-оос хуваарилсан зардлын төсөв

№	Зардлын нэр						/мянган төгрөг/	
		СЕХ-НИЙ 2024.04.1 6-НИЙ 3/229	СЕХ-НИЙ 2024.05.0 2-НЫ 3/290	СЕХ-НИЙ 2024.05.2 1-НЫ 3/373	СЕХ-НИЙ 2024.06.0 9-НИЙ 3/472	СЕХ-НИЙ 2024.06.1 8-НИЙ 3/562	НИЙТ	
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	-	-	-	-	300.0	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	10,967.0	-	-	-	-	10,967.0	
3	МТБ, даамлын сургалт	-	23,730.0	-	-	-	23,730.0	
4	Бичиг хэрэг	-	16,450.0	-	-	-	16,450.0	
5	Шуудан холбоо	-	19,600.0	-	-	-	19,600.0	
6	Унаа	-	85,260.0	-	-	-	85,260.0	
7	Санал авах байр бэлтгэх	-	-	32,550.0	-	-	32,550.0	
8	Сурталчилгаа	-	-	8,000.0	-	-	8,000.0	
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах, хүргэх ачаа, томилолтын зардал	-	-	-	53,204.0	-	53,204.0	
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	-	-	-	1,300.0	-	1,300.0	
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	-	-	-	-	670,824.0	670,824.0	
12	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, НДШ	-	-	-	-	80,696.0	80,696.0	
13	Хоолны зардал	-	-	-	-	61,000.0	61,000.0	
14	Томилолтын зардал	-	-	-	-	13,032.0	13,032.0	
15	Шуурхай багийн зардал	-	-	-	-	2,130.0	2,130.0	
16	Болзошгүй зардал	-	-	-	-	10,080.0	10,080.0	
<b>Нийт дүн</b>		<b>11,267.0</b>	<b>145,040.0</b>	<b>40,550.0</b>	<b>54,504.0</b>	<b>837,762.0</b>	<b>1,089,123.0</b>	

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгохоор баталсан төсөв нь УИХ-ын 2020 оны сонгуулийн зардлын төсвөөс бараг 2 дахин их буюу 530,648.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Өмнөх УИХ-ын 2020 оны сонгуулийн зардлын төсөвтэй харьцуулсан судалгааг дэлгэрэнгүй байдлаар харуулбал:

Хүснэгт № 3. УИХ-ын 2020, 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс баталсан төсөв, гүйцэтгэл

УИХ-ын ээлжит сонгууль	Сонгуулийн хороо	СХ- НЫ ТОО	ХХ- НИЙ ТОО	Батлаг дсан төсөв	/Мянган төгрөг/	
					Гүйцэт гэл	Үлдэгд эл
	Аймгийн Сонгуулийн хороо	1		129,887.5	129,878.5	9.0



УИХ-ын 2020 оны ээлжит  
сонгууль

**Нийт дүн**

УИХ-ын 2024 оны ээлжит  
сонгууль

**Нийт дүн**

Сумын Сонгуулийн хороо	19	105	428,587.5	428,503.5	84.0
	<b>20</b>	<b>105</b>	<b>558,475.0</b>	<b>558,382.0</b>	<b>93.0</b>
Аймгийн Сонгуулийн хороо	1		61,080.3	45,234.0	15,846.3
Сумын Сонгуулийн хороо	19	105	1,028,042.7	1,028,042.6	0.1
	<b>20</b>	<b>105</b>	<b>1,089,123.0</b>	<b>1,073,276.6</b>	<b>15,846.4</b>

Аймгийн Сонгуулийн хороо нь СЕХ-оос ирүүлсэн 5 удаагийн төсвийн хуваарь, төсвийг зарцуулах тайлбар, аргачлалын дагуу УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс олгосон нийт төсвийн 94.4 хувь буюу 1,028,042.7 мянган төгрөгийг 19 сумын сонгуулийн хороо, 105 хэсгийн хороонд, 5.6 хувь буюу 61,080.3 мянган төгрөгийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар тус тус хуваарилсан байна.

Хүснэгт №4. УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон төсвийг аймгийн сонгуулийн хороо болон 19 сумын сонгуулийн хороодод хуваарилсан байдал

№	Сумдын нэр	Сонгууль зохион байгуулахтай холбогдсон		/Мянган төгрөг/ Үлдэгдэл
		Төсөв	Гүйцэтгэл	
1	Ихтамир	57,632.1	57,632.1	-
2	Чулуут	50,027.9	50,027.9	-
3	Хангай	58,918.0	58,917.9	0.1
4	Тариат	66,819.0	66,819.0	-
5	Өндөр-улаан	49,916.6	49,916.6	-
6	Эрдэнэмандал	58,464.4	58,464.4	-
7	Жаргалант	50,584.4	50,584.4	-
8	Цэцэрлэг	50,269.4	50,269.4	-
9	Хайрхан	50,160.2	50,160.2	-
10	Батцэнгэл	57,895.3	57,895.3	-
11	Өлзийт	41,696.4	41,696.4	-
12	Өгийнуур	49,778.0	49,778.0	-
13	Хашаат	50,219.0	50,219.0	-
14	Хогонт	57,985.6	57,985.6	-
15	Цэнхэр	57,605.5	57,605.5	-
16	Төвшрүүлэх	41,100.0	41,100.0	-
17	Булган	41,089.5	41,089.5	-
18	Цахир	42,221.4	42,221.4	-
19	Эрдэнэбулган	95,660.0	95,660.0	-
20	Аймгийн сонгуулийн хороо	61,080.3	45,234.0	15,846.4
<b>НИЙТ ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ</b>		<b>1,089,123.00</b>	<b>1,073,276.52</b>	<b>15,846.48</b>

### 1.1.3. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ТӨСВИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛСАН БАЙНА

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгууль зохион байгуулах зардлын төсвийг 98.9 сая төгрөгөөр, 2024 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардлын төсвийг 4.5 сая төгрөгөөр нийт 103.5 сая төгрөгийг, Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан хамгаалалтын зардлын



төсвөөс Архангай аймгийн Цагдаагийн газарт 39.8 сая төгрөгийг тус тус төлөвлөж хуваарилсан байна. Хуваарилсан төсвийг зардлын эдийн засгийн анги хооронд шилжүүлээгүй зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт №5. Батлагдсан төсвийг зардлын ангиллаар харуулбал:

Байгууллагын нэр	Зардлын нэр	/мянган төгрөг/	
		Төсөв	Зардлын эзлэх хувь
Улсын бүртгэлийн хэлтэс	Улсын бүртгэлийн ажилтан	4,000.0	3.9
	Итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны урамшуулал	64,597.5	62.4
	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардлын төсөв	4,270.8	4.1
	СНЖ-ыг хороодод хүргэх зардал	2,052.0	2.0
	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлын төсөв	14,490.0	14.0
	Сургалтын бусад зардал	2,120.0	2.0
	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардлын төсөв	7,436.0	7.2
	Тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардлын төсөв	4,536.0	4.4
<b>Дүн</b>		<b>103,502.3</b>	<b>100.0</b>
Цагдаагийн газар	Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах алба хаагчдын хоолны мөнгө	26,712.0	67.1
	Шуудан холбооны зардал	11,110.0	27.9
	Шатахуун	2,000.0	5.0
<b>Дүн</b>		<b>39,822.0</b>	<b>100.0</b>
<b>Нийт дүн</b>		<b>143,324.3</b>	<b>-</b>

Эх сурвалж: цагдаа, УБХ-ийн сонгуулийн зардлын тайлан

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан төсвийн 62.4 хувийг итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны урамшуулал, 14 хувийг сургалт зохион байгуулахтай холбоотой зардлууд эзэлж байгаа нь зардлын ихэнх хувь байна. Цагдаагийн газарт хуваарилсан төсвийн 67.1 хувь нь өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах алба хаагчдын хоолны зардал байна.

Хүснэгт №6. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар аймгийн Сонгуулийн хороо, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв, гүйцэтгэл

Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	/мянган төгрөг/
				Гүйцэтгэлийн хувь
Аймгийн сонгуулийн хороо	1,089,123.0	1,073,276.5	15,846.5	98.5
Аймгийн Цагдаагийн газар	39,822.0	39,822.0	-	100.0
Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	103,502.3	100,882.5	2,619.8	97.5

**БҮЛЭГ 2. ЗАРИМ СОНГУУЛИЙН ХОРООД НЬ ТӨСВИЙГ ЗАРЦУУЛАХДАА ХОЛБОГДОХ  
ЖУРМЫН ШААРДЛАГЫГ МӨРДӨӨГҮЙ БАЙНА****2.1.1. СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООД НЬ 2,957.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН ЗАРДЛЫГ ЭДИЙН  
ЗАСГИЙН АНГИЛАЛ ХООРОНД ШИЛЖҮҮЛЭН ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

СЕХ-оос Архангай аймгийн сонгуулийн хороонд 1,089,123.0 мянган төгрөг хуваарилж, гүйцэтгэлээр 1,073,276.0 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэлтээр үлдсэн 15,846.5 мянган төгрөгийг СЕХ-нд буцаан төвлөрүүлсэн байна.

Санхүүжилтийн гүйцэтгэлийг шалгахад зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан 7 сумын Сонгуулийн хороонд хамаарах 1,180.0 мянган төгрөгийн, хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан 1,360.0 мянган төгрөгийн, анхан шатны баримтгүйгээр томилолт олгосон 417.0 мянган төгрөгийн нийт 2,957.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Хүснэгт № 7. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	/мянган төгрөг/ Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.00	300.00	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	10,967.00	10,967.00	-
3	МТБ, Даамлын сургалт	23,730.00	22,028.97	1,701.03
4	Бичиг хэрэг	16,450.00	16,489.30	(39.30)
5	Шуудан холбоо	19,600.00	17,880.00	1,720.00
6	Унаа	85,260.00	86,010.00	(750.00)
7	Санал авах байр бэлтгэх	32,550.00	32,460.00	90.00
8	Сурталчилгаа	8,000.00	6,746.45	1,253.55
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх ачаа томилолтын зардал	53,204.00	47,944.60	5,259.40
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.00	1,300.00	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	670,824.00	670,824.00	-
12	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, НДШ	80,696.00	80,696.00	-
13	Хоолны зардал	61,000.00	61,000.00	-
14	Томилолтын зардал	13,032.00	12,330.20	701.80
15	Шуурхай багийн зардал	2,130.00	-	2,130.00
16	Болзошгүй зардал	10,080.00	6,300.00	3,780.00
<b>НИЙТ ДҮН</b>		<b>1,089,123.00</b>	<b>1,073,276.52</b>	<b>15,846.48</b>

**Аудитын илрүүлэлт:**

1. СЕХ-ний 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.2<sup>1</sup>, 3.6<sup>2</sup> дахь заалтыг зөрчиж дараах сумын сонгуулийн хороод төсвийг эдийн засгийн хороонд гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

- Өлзийт сумын СХ нь 150.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд;
- Өндөр-Улаан сумын СХ нь 30.0 мянган төгрөгийн бичиг хэргийн, 150.0 мянган төгрөгийн шуудан холбооны нийт 180.0 мянган төгрөгийг шатахуунд;
- Ихтамир сумын СХ нь 210.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд;
- Булган сумын СХ нь 90.0 мянган төгрөгийн санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлыг бичиг хэргийн зардалд;
- Эрдэнэмандал сумын СХ нь 210.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд;

<sup>1</sup> 3.2 Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

<sup>2</sup> 3.6 Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна.



2. Дараах сумын сонгуулийн хороод баталсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.  
Үүнд:
  - Жаргалант сумын СХ нь хэсгийн хорооны санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлаас 340.0 мянган төгрөгийг сумын СХ-ны байрыг тохижуулахад зарцуулсан нь СЕХ-ний 2024.05.21-ны өдрийн 3/373 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарын 1 дэх хэсгийг зөрчсөн байна.
3. Анхан шатны баримтгүй болон татварыг дутуу суутгасан дараах зөрчил илэрлээ.  
Үүнд:
  - Эрдэнэмандал сумын СХ нь албан хаагчид олгох урамшууллын зардлаас 1,360.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан нь ХХОАТ-ын тухай хуулийн 21.1<sup>3</sup> дэх заалтыг зөрчсөн байна.
  - Булган сумын СХ нь 2 даамалд анхан шатны баримтгүйгээр томилолтын 417.0 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас хувь хүний орлогын албан татварыг дутуу суутгасан 1,360.0 мянган төгрөг, анхан шатны баримтгүй зарцуулсан 417.0 мянган төгрөг, нийт 1777.0 мянган төгрөгийг холбогдох албан хаагчдаас гаргуулан аймгийн орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг таслан зогсоож алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг зөрчил гаргасан сумын сонгуулийн хороодод хүргүүлэв.

## 2.1.2. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГ 13 СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭР ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сумдын сонгуулийн хорооны тайланг СЕХ-ний 2024.06.30-ны өдрийн 3/667 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн сонгуулийн хорооны төсвийн хуваарийн дагуу бэлтгэж ирүүлснийг аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч хүлээж авсан байна.

Сумдын ирүүлсэн зардлын тайланг анхан шатны баримтаас тулган шалгахад 13 сумын сонгуулийн хороод нийт 21,472.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдаа илэрсэн ба аудитын явцад зардлын тайланг анхан шатны баримтын дагуу залруулж дахин бэлтгүүлэв.

### Хүснэгт -8. Сумын сонгуулийн хорооны зардлын тайлан, аудитаар байвал зохих зардлын тайлангийн залруулга хийсэн дүнг харуулбал

Сонгуулийн хорооны нэр	Сумын сонгуулийн хорооны зардлын тайлангаар						Аудитаар байвал зохих					Нийт
	Унаа	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гаргах зардал	Томилолтын зардал	Нийт	Шуудан холбоо	Бичиг хэрэг	Сургалтын зардал	Унааны зардал	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гаргах зардал	Томилолтын зардал	Болзоошгүй зардал	
Батцэнгэл	1,017.3	2,680.6		<b>3,697.9</b>			1,399.1		1,938.8		360.0	<b>3,697.9</b>
Өлзийт	1,208.4			<b>1,208.4</b>	150.0		285.6		585.2	187.6		<b>1,208.4</b>
Хашаат	1,581.0	-		<b>1,581.0</b>			357.0		686.0	238.0	300.0	<b>1,581.0</b>
Төвшрүүлэх	462.0			<b>462.0</b>			84.0		322.0	56.0		<b>462.0</b>
Өндөр-Улаан	1,628.6			<b>1,628.6</b>	150.0	30.0	256.2		891.6	0.8	300.0	<b>1,628.6</b>
Ихтамир	604.1			<b>604.1</b>	210.0		52.5		303.8	37.8		<b>604.1</b>
Хайрхан	55.4			<b>55.4</b>			55.4					<b>55.4</b>
Эрдэнэмандал	1,044.8			<b>1,044.8</b>	210.0		119.0		136.0	219.8	360.0	<b>1,044.8</b>
Хангай		842.9	1,718.0	<b>2,560.9</b>			714.5	1,846.4				<b>2,560.9</b>
Цахир	310.8		1,869.2	<b>2,180.0</b>			990.0		1,190.0			<b>2,180.0</b>
Булган			1,869.5	<b>1,869.5</b>			371.5		1,498.0			<b>1,869.5</b>
Чулуут	115.5		2,302.2	<b>2,417.7</b>			1,235.5		1,182.2			<b>2,417.7</b>

<sup>3</sup> 21.1 Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.



Жаргалант		2,162.2		2,162.2			1,120.0		1,042.2			2,162.2
Нийт	8,027.9	5,685.7	7,758.9	21,472.5	720.0	30.0	7,040.3		9,775.8	740.0	1,320.0	21,472.5

### 2.1.3. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС СУМДЫН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аймгийн Сонгуулийн хорооноос 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 25-ны хооронд, 06 дугаар сарын 22-ны өдрөөс 6 дугаар сарын 28-ны өдрийн хооронд Эрдэнэмандал, Цэцэрлэг, Жаргалант, Тариат, Хайрхан, Хотонт, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Төвшрүүлэх, Цэнхэр зэрэг нийт 11 сумын сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой 19 сумын сонгуулийн хороодын үйл ажиллагааны баримт, материалыг тойрох хуудсаар баталгаажуулан хүлээн авсан байна. Гэвч 7 сумын сонгуулийн хороод нийт 3,057.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хороонд шилжүүлсэн, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, татварыг дутуу суутган тооцсон, 13 сумын сонгуулийн хороод сонгуулийн зардлын тайланг бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй нь СЕХ-ний 2021 оны А/17 тушаалаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.8<sup>4</sup>, 3.10<sup>5</sup>, 4.6<sup>6</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаас баталсан төсвийг зориулалт бус болон зардлын ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, бодит гүйцэтгэлээр тайлагнах талаар сумын сонгуулийн хороонд тавих хяналтын үр дүнг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэв.

----- ооОоо -----

<sup>4</sup>3.8 хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ

<sup>5</sup> 3.10-д “... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны ... сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавина”

<sup>6</sup> 4.6-д “аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч ... архивд албан ёсоор хүлээлгэн өгнө”



## АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- ✓ УИХ-ын 2024 оны сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс Архангай аймгийн сонгуулийн хороонд олгосон 1,089,123.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хууль, журмын дагуу хуваарилж зарцуулсан байна.
- ✓ Сумын сонгуулийн хороод батлагдсан төсвөөс 1,777.0 мянган төгрөгийг зориулалт бус, 1,180.0 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан байна
- ✓ Аймгийн сонгуулийн хорооноос сумын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

**Аудитын дүн:** Аудитаар нийт **21,472.5** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулав. Харин **2,957.0** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **1,777.0** мянган төгрөгийн зөрчилд **2** төлбөрийн акт, **1,180.0** мянган төгрөгийн зөрчилд **6** албан шаардлага, **1** заалт бүхий зөвлөмжийг аймаг, сумдын сонгуулийн хороодод хүргүүллээ.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:** “НИЙТ 2,957.0 МЯНГАН ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ ИЛЭРСНИЙГ ЭС ТООЦВОЛ УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛЖ, ЗАРДЛЫГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА”



## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **Аймгийн Сонгуулийн хорооны даргад**

1. Баталсан төсвийг зориулалт бус болон зардлын ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй байх, бодит гүйцэтгэлээр тайлагнах талаар сумын сонгуулийн хороонд тавих хяналтын үр дүнг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсний дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 09 дүгээр сарын 5-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, нотлох баримтыг хангуулан 2024 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



### АРХАНГАЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

2 дугаар баг, Эрдэнэбулган сум,  
Архангай аймаг, 65139, Утас: 7033 3800,  
Цахим шуудан: arsonguuli@gmail.com  
Цахим хаяг: www.gec.gov.mn

2024.07.29 № 33

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нэмэлт тайлбар, санал байхгүй болно.

ДАРГА



Ш.ГОМБОДОРЖ

*А. Сүхбат* 7.29.24 - 2024.07.29

*Мөнхмүрэн*

*2024.07.29*



## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### АРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 29 өдөр

Дугаар А128

Эрдэнэбулган сум

#### Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах" /ГНАГ-2024/06-ШТА-НА/ кодтой нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

3.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газарт болон аймгийн Сонгуулийн хорооны даргад тус тус хүргүүлсүгэй.

р4.Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



D:\2024\Тушаал.doc

650210085



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/28 дугаар тушаалын хавсралт №1

"Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах" нийшлийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитын код: ГНАГ-2024/06-ШТА-НА

№	Хүргүүлсэн шийдвэрийн				Хэрэгжилтийг хариуцах		
	Зөрчлийн утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Тоо	Шийдвэр	Шийдвэрийн огноо дугаар	Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Өлзийт сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг зардлын ангилал болон анхан шатны баримтаар тулган шалгахад 150.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан.	150,000.00	1	Албан шаардлага	2024.07.26 407/A0370220	Өлзийт сумын Сонгуулийн хорооны дарга	Б.Очир-Эрдэнэ
2	Өндөр-Улаан сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг зардлын ангилал болон анхан шатны баримтаар тулган шалгахад бичиг хэргийн 30.0 мянган, шуудан холбооны 150.0 мянган төгрөгийн зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан.	180,000.00	1	Албан шаардлага	2024.07.26 406/A0370220	Өндөр-Улаан сумын Сонгуулийн хорооны дарга	С.Вандандулам
3	Ихтамир сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг зардлын ангилал болон анхан шатны баримтаар тулган шалгахад 210.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан.	210,000.00	1	Албан шаардлага	2024.07.26 405/A0370220	Ихтамир сумын Сонгуулийн хорооны дарга	Д.Нямжаргал
4	Эрдэнэмандал сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг зардлын ангилал болон анхан шатны баримтаар тулган шалгахад 210.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан.	210,000.00	1	Албан шаардлага	2024.07.26 404/A0370220	Эрдэнэмандал сумын Сонгуулийн хорооны дарга	З.Батмөнх
5	Булган сумын СХ нь хэсгийн хорооны санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлаас 90.0 мянган төгрөгийг бичиг хэргийн материал бэлтгэж зориулалт бус зарцуулсан.	90,000.00	1	Албан шаардлага	2024.07.26 409/A0370219	Булган сумын Сонгуулийн хорооны дарга	Н.Бат-Эрдэнэ
6	Жаргалант сумын СХ нь хэсгийн хороодын тохижилтын зардлаас сумын сонгуулийн хорооны байрыг тохижуулахад 340.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.	340,000.00	1	Албан шаардлага	2024.07.26 408/A0370219	Жаргалант сумын Сонгуулийн хорооны дарга	Э.Бөхбаатар
7	Булган сумын СХ нь 417.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг анхан шатны баримтгүйгээр шилжүүлсэн.	417,000.00	1	Төлбөрийн акт	2024.07.26 66/A0370219	Булган сумын Сонгуулийн хорооны дарга	Н.Бат-Эрдэнэ
8	Эрдэнэмандал сумын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг зардлын ангилал болон анхан шатны баримтаар тулган шалгахад 1,360.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан.	1,360,000.00	1	Төлбөрийн акт	2024.07.26 65/A0370220	Эрдэнэмандал сумын Сонгуулийн хорооны дарга	З.Батмөнх
<b>Албан шаардлага</b>		<b>1,180,000.00</b>	<b>6</b>				
<b>Төлбөрийн акт</b>		<b>1,777,000.00</b>	<b>2</b>				
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2,957,000.00</b>	<b>8</b>				



# ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт 1

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, сонгуулийн хорооны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Тойргийн дугаар	Мандатын тоо	Аймаг, Нийслэлийн сонгуулийн хорооны нэр	Сум, дүүргийн сонгуулийн хорооны тоо	Хэсгийн хорооны тоо	Сонгуулийн насны иргэдийн тоо	Сонгууль өгсөн иргэдийн тоо	Батлагдсан төсөв /мянган төгрөг/	Зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/
			Архангай	19	105	59471	39804	1,089,123.00	1,073,276.52	15,846.48
	Тойргийн дүн		Нийт дүн	19	105	59471	39804	1,089,123.00	1,073,276.52	15,846.48

Судалгаа нэгтгэсэн: Ахлах аудитор

Судалгаа хянасан: Аудитын менежер

Огноо:

Г.Цог-Эрдэнэ

Д.Нэргүйбаатар



Хавсралт 2

УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой Архангай аймагт улсын төсвөөс  
санхүүжүүлсэн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгтгэл

/мян.төг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.00	300.00	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	10,967.00	10,967.00	-
3	МТБ, Даамлын сургалт	23,730.00	22,028.97	1,701.03
4	Бичиг хэрэг	16,450.00	16,489.30	(39.30)
5	Шуудан холбоо	19,600.00	17,880.00	1,720.00
6	Унаа	85,260.00	86,010.00	(750.00)
7	Санал авах байр бэлтгэх	32,550.00	32,460.00	90.00
8	Сурталчилгаа	8,000.00	6,746.45	1,253.55
9	Саналын хуудас, төхөөрөмжийн авах хүргэх ачаа томилолтын зардал	53,204.00	47,944.60	5,259.40
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.00	1,300.00	-
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	670,824.00	670,824.00	-
12	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, НДШ	80,696.00	80,696.00	-
13	Хоолны зардал	61,000.00	61,000.00	-
14	Томилолтын зардал	13,032.00	12,330.20	701.80
15	Шуурхай багийн зардал	2,130.00	-	2,130.00
16	Болзошгүй зардал	10,080.00	6,300.00	3,780.00
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,089,123.00</b>	<b>1,073,276.52</b>	<b>15,846.48</b>

Жич: Аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллага тойрог тус бүрээр нэгтгэн ирүүлнэ.

Судалгаа нэгтгэсэн: Ахлах аудитор

Судалгаа хянасан: Аудитын менежер

Огноо:

Г.Цог-Эрдэнэ

Д.Нэргүйбаатар



Хавсралт 3

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулсан сонгуулийн хорооны удирдах албан тушаалтны талаарх судалгаа

№	Сонгуулийн хорооны нэр	Сонгуулийн хорооны дарга					Сонгуулийн хорооны нягтлан бодогч				
		Овог, Нэр	Томилгодсон тушаалын огноо, дугаар	Мэргэжил	Эрхлэж буй ажил, албан тушаал	Овог, Нэр	Томилгодсон тушаалын огноо, дугаар	Мэргэжил	Эрхлэж буй ажил, албан тушаал		
1	Аймгийн Сонгуулийн хороо	Шагдарсүрэнгийн ГОМБОДОРЖ	2024.04.16 №23	Багш	Аймгийн ЗДТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	Цэрэнбатын Батцэцэг	2024.04.17 №01	Нягтлан бодогч	Аймгийн ЗДТГ-ын ерөнхий нягтлан бодогч		
2	Ихтамир	Даржаа НЯМЖАРГАЛ	2024.04.28 №2	Төрийн удирдлага	Ихтамир сумын ЗДТГ-ын дарга	ТОГТОХБАРГАЛ ОТГОНЖАРГАЛ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Ихтамир сумын Төрийн сангийн мэргэжилтэн		
3	Чулуут	Цэвэгбат МӨНХБАТ	2024.04.28 №2	Түүх нийгмийн ухаан багш	Чулуут сумын ЗДТГ-ын дарга	Цэндсүрэн СУВДМАА	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Чулуут сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч		
4	Хангай	Мягваринчин БАТБОЛД	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Хангай сумын ЗДТГ-ын дарга	Батогоо ОЮУННОМИН	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Хангай сумын ЗДТГ-ын нягтлан бодогч		
5	Тариат	Арвдан ТҮМЭНБЯАР	2024.04.28 №2	Төрийн удирдлагын магистр	Тариат сумын ЗДТГ-ын дарга	Галбадр ГАНТАМИР	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Тариат сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч		
6	Өндөр-улаан	Сумъяа ВАНДАНДУЛАМ	2024.04.28 №2	Эрх зүйч	Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын дарга	Ёндон ЭРДЭНЭЦЭЦЭГ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Өндөр-Улаан сумын ЕБС-ийн нягтлан бодогч		
7	Эрдэнэмандал	Загд БАТМӨНХ	2024.04.28 №2	Эдийн засагч	Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын дарга	Нямдаваа ОТГОНТУЯА	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Эрдэнэмандал сумын ЕБС-ийн нягтлан бодогч		
8	Жаргалант	Энхтүвшин Бөхбаатар	2024.04.28 №2	Төрийн удирдлагын магистр	Жаргалант сумын ЗДТГ-ын дарга	Баасандорж ЭРДЭНЭБААТАР	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Жаргалант сумын хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн		
9	Цэцэрлэг	Балжинням ЭНХСАРУУЛ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Цэцэрлэг сумын ЗДТГ-ын дарга	Энхтайван МӨНХ-ӨЛЗИЙ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Цэцэрлэг сумын ЗДТГ-ын нягтлан бодогч		
10	Хайрхан	Жалбуу ОЮУНТУЯА	2024.04.28 №2	Багш	Хайрхан сумын ЕБС-ийн захирал	Дандар УЯНГА	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Хайрхан сумын ЗДТГ-ын нягтлан бодогч		
11	Батцэнгэл	Шараа НЭРГҮЙБААТАР	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Батцэнгэл сумын ЗДТГ-ын дарга	Амарсайхан ПҮРЭВСҮРЭН	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Батцэнгэл сумын ЗДТГ-ын нягтлан бодогч		
12	Өлзийт	Балжинням ОЧИР-ЭРДЭНЭ	2024.04.28 №2		Өлзийт сумын ЗДТГ-ын дарга	Чойжилсүрэн ОДОНТУЯА	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Өлзийт сумын ЭМТ-ийн нягтлан бодогч		
13	Өгийнуур	Доржсүрэн ТҮВШИНБААТАР	2024.04.28 №2	Программ хангамж	Өгийнуур сумын ЗДТГ-ын дарга	Таванжин ДАШДОНДОВ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Өгийнуур сумын ЗДТГ-ын нягтлан бодогч		
14	Хашаат	Алтангэрэл АРИУНБУЯН	2024.04.28 №3	Төрийн удирдлагын магистр	Хашаат сумын ЗДТГ-ын дарга	Дашзэвэг ЗОРИЙТ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Хашаат сумын ЗДТГ-ын нягтлан бодогч		
15	Хотонт	Аюурзана ОЮУНАА	2024.04.28 №2	Багш	Хотонт сумын ЗДТГ-ын дарга	Жамсранжав ОТГОНБАЯР	2024.05.15 №5	Нягтлан бодогч	Хотонт сумын ЕБС-ийн нягтлан бодогч		



16	Цэнхэр	Энэбишийн БОЛОРЦЭЦЭГ	2024.04.28 №2	Төрийн улирдалын магистр	Цэнхэр сумын ЗДТГ-ын дарга	Цэнд-Аюушийн СОСОРБАРАМ	2024.05.17 №2	Нягтлан бодогч	Цэнхэр сумын Нийгмийн даатгалын улсын байцаагч
17	Төвшрүүлэх	Сүндүйрэвдан ӨЛЗИЙЖАРГАЛ	2024.04.28 №2	Төрийн улирдалын магистр	Төвшрүүлэх сумын ЗДТГ- ын дарга	Буян-Өлзий АЛТАНЦЭЦЭГ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Төвшрүүлэх сумын ЗДТГ-ын Санхүү албаны дарга
18	Булган	Нямцэнд БАТ- ЭРДЭНЭ	2024.04.28 №2	Эрх зүйч	Булган сумын ЗДТГ-ын дарга	Булгантамир БАТСҮХ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Булган сумын төрийн сангийн мэргэжилтэн
19	Цахир	Санжаа БАТСАЙХАН	2024.04.28 №2	Инженер	Цахир сумын ЗДТГ-ын дарга	Даваа ОЮУНГЭРЭЛ	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Цахир сумын төсвийн ерөнхий нэгтгэн бодогч
20	Эрдэнэбулган	Очирсүрэн ЖАВЗАНСҮРЭН	2024.04.28 №2	Багш	Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын дарга	Чагнаадорж ДООСМАА	2024.04.28 №2	Нягтлан бодогч	Эрдэнэбулган сумын 9-р цэцэрлэгийн нягтлан бодогч

Г. Цог-Эрдэнэ  
  
Д. Нэргүйбаатар

Судалгаа нэгтгэсэн: Ахлах аудитор  
Судалгаа хянасан: Аудитын менежер

Огноо:





Хавсрафт 4

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах"  
Аудитын код: ГНАГ-2024/06-ШТА-НА  
Байгууллагын нэр: Архангай аймаг дахь Төрийн Аудитын газар

№	Аудитын чиглэл /Асуулт/	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэр	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
1		2	3	4	5	6
1		Өлзийт сумын Сонгуулийн хороо нь 150.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан байна.	150.00	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх		Албан шаардлага
2		Өндөр-Улаан сумын СХ нь бичиг хэргийн 30.0 мянган шуудан холбооны 150.0 мянган төгрөгийн зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан байна.	180.00	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх		Албан шаардлага
3		Ихтамир сумын СХ нь 210.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан байна.	210.00	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх		Албан шаардлага
4		Эрдэнэмандал сумын СХ нь 210.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардлыг шатахуунд гүйлгэн зарцуулсан байна.	210.00	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх		Албан шаардлага
5	1.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу ариалан хэмнэлттэй зарцуулсан уу?	Эрдэнэмандал сумын СХ нь 1,360.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дууу суутгасан зөрчил илэрсэн.	1,360.00	Төлбөрийн акт тогтоох		Төлбөрийн акт
6		Булган сумын СХ нь 417.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг анхан шатны баримтгүйгээр шилжүүлсэн зөрчил байна.	417.00	Төлбөрийн акт тогтоох		Төлбөрийн акт
7		Булган сумын СХ нь хэсгийн хорооны санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлаас 90.0 мянган төгрөгийг бичиг хэргийн материал бэлтгэж зориулалт бус зарцуулсан зөрчил илэрсэн.	90.00	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх		Албан шаардлага
8		Жаргалант сумын СХ нь хэсгийн хорооны тохижилтын зардлаас сумын сонгуулийн хорооны байрыг тохижуулахад 340.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь СЕХ-ний 2024.05.21-ны өдрийн 3/373 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарын 1 дэх хэсгийг зөрсөн байна.	340.00	Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх		Албан шаардлага
9	2.1.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн үү	Аймгийн Сонгуулийн хорооноос 11 сумын сонгуулийн хороодод хяналт тавьж ажилласан хэдий ч аудитаар 7 сумын сонгуулийн хороод нийт 3,057.0 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хороонд шилжүүлсэн, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, татварыг дууу суутган тооцсон, 13 сумын сонгуулийн хороод сонгуулийн зардлын тайланг бодит гүйцэтгэлээр тайлагнаагүй байгаа нь хяналт үр дүнгүй байна.	2,957.00	Баталсан төсвийг зориулалт бус болон зардлын ангилал хороонд шилжүүлэн зарцуулахгүй байх, бодит гүйцэтгэлээр тайлагнах талаар сумын сонгуулийн хороонд тавих хяналтын үр дүнг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх		Аймгийн Сонгуулийн хороонд зөвлөмж хүргүүлэх

Бэлтгэсэн:   
Ахлах аудитор: Г.Цог-Эрдэнэ  
Аудитор: Н.Энхчигээг  
Аудитор: П.Соёлмөнх  
Хоёр дах шатанд хянасан: Д.Нэргүйбаатар  
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа